



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 464

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нэхсөн, 5,000,000.00 (таван сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Содномжамц, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Ш.Энхтөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланц тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002361

D:\Huraldaanii material\2018 on\2018.10.23\Togtool.docx

Төрийн өмчийн бодлогыг зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

**ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДСЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРГЭЛТЭЙ,  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДАГ ААР ХУДАЛДАХ АВТОМАШИН**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арагл, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуrimтлагдсан элээдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Волксваген, 32-43 УНЕ, WV1ZZZ2DZWHO12923	2009.09.22	342 000	5 000 000,00	5 000 000,00	-	-	1 000 000,00
	<b>НИЙТ ДҮН</b>	-	-	<b>5,000,000.00 (таван сая)</b>	<b>5,000,000.00 (таван сая)</b>	-	-	<b>1,000,000.00 (нэг сая)</b>